



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/100

Ховд


Шүүхийн шийдвэртэй өр барагдуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсөвт байгууллагуудад дулаан халаалтын үйлчилгээг үзүүлж буй хувийн хэвшлийн байгууллагуудын эрх бүхий байгууллагаас баталсан төлбөрийн үнэлгээгээр тооцсон халаалтын хөлс болон дулаан ашиглагч төсөвт байгууллагуудын жил бүрийн халаалтын батлагдсан төсвийн зөрүүгээс үүссэн өрийг төлүүлэх тухай Ховд аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн 225,726,166 төгрөг /хоёр зуун хорин таван сая долоон зуун хорин зургаан мянга нэг зуун жаран зургаан/-ийг хавсралтаар баталж халаалтын өрийг барагдуулахаар зарцуулсугай.


2. Тус арга хэмжээнд зарцуулах 225,726,166 төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд зохицуулалт хийж 2022 онд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 04-ний өдрийн
А/100 дугаар захирамжийн хавсралт



БАЙГУУЛЛАГУУДЫН ХАЛААЛТЫН ӨРИЙГ БАРАГДУУЛАХ ЖАГСААЛТ

Д/д	Хүлээн авах байгууллагын нэр	Шүүхийн шийдвэрийн он сар, өдөр, дугаар	Төлбөр тооцогдох он, сар	Нийт дүн /төгрөгөөр/
1	Чандмань сумын Эрүүл мэндийн төв	2021.11.29 №153/ШЗ2021/02285	2020 он, 2021 оны 4 сар	21848868.00
2	Чандмань сумын Соёлын төв	2021.11.29 №153/ШЗ2021/02286	2020 он, 2021 оны 4 сар	29552306.00
3	Чандмань сумын Ерөнхий боловсролын сургууль	2021.11.29 №153/ШЗ2021/02287	2020 он, 2021 оны 4 сар	121736560.00
4	Чандмань сумын Засаг даргын Тамгын газар	2021.11.11 №153/ШЗ2021/02147	2020.01-2021.04 сар	2256120.00
5	Дуут сумын Эрүүл мэндийн төв	2021.12.06 №153/ШЗ2021/02359	2021.01-2021.04 сар	11127334.00
6	Дуут сумын Засаг даргын Тамгын газар	2021.12.06 №153/ШЗ2021/02358	2020.01-2021 оны 4 сар	2544858.00
7	Дуут сумын Соёлын төв	2021.12.06 №153/ШЗ2021/02360	2021 оны 1-4 сар	36660120.00
		Нийт дүн		225726166.00

-oOo-